

БАТЛАВ:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА А.КАМЕЛИЯТ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН ТӨВИЙН
3,5 КМ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 10 дугаар сарын 30-ний өдөр 01/2023

Баяннуур сум

- | | |
|--|---|
| 1. Зураг төсөл боловсруулах үндэслэл | Баян-Өлгий аймгийн ИТХ-ийн ээлжит хуралын тогтоолын дагуу |
| 2. Байршил | Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын төв 4 дүгээр баг |
| 3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар |
| 4. Замын техникийн ангилал, замын зэрэг, хүчин чадал | Авто замын зэрэглэл 2А, 3А |
| 5. Замын хучлага | Тооцоогоор |
| 6. Хучилтын хэлбэр | Тооцоогоор |
| 7. Төлөвлөлтийн норм | <ul style="list-style-type: none">• “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016• “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12;• “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004• “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01*/2006• “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009• Хот суурины гудамж зам төлөвлөлт” БНБД 32-01-04 |
| 8. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | Нарийвчилсан зураг төслийг 2023 оны 9 дүгээр сард багтаан гүйцэтгэнэ. |
| 9. Зураг төслийн иж бүрдэл | <ul style="list-style-type: none">• “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн хавсралт 2-8-ыг баримтлана.• Инженер-геологийн судалгааны ажлын тайлан Карьерын судалгаа /Зам барилгын ажилд хэрэглэх дүүргэгч материал тус бүрээр/ |

- Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах;
- Инженерийн нарийвчилсан зураг
- Геодезийн хэмжилтийн тайлан
- Хучилтын тооцоо
- Зургийн тайлбар бичиг
- Техникийн шаардлага
- Авто замын трасст орсон шугам сүлжээг шилжүүлэх ажлын зураг төсөл
- Ус зайлуулах байгууламжийн тооцоо
- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ Барилгын ажлын нэгдсэн төсөв
- Ажил гүйцэтгэх аргачлал
- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт
- Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрлүүд

10. Зураг төслийн байгууллага

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол Улсын хуулийн дагуу сонгон шалгаруулна.

11. Захиалагч байгууллага

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар

12. Онцгой нөхцөл

- Аймаг, сум орон нутгийн ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөртэй уялдуулах, санал авах;
- Хучилтын бүтээцийг ЗТБХБСайдын 2010 оны 313 дугаар тушаалаар батлагдсан “Монгол орны асфальтбетон хучлагтай авто замын хучилтын хийцийн жишиг цомог”-ийг жишиг болгох;
- Суурь үеийг зохист найрлага бүхий материалыг цемент болон түүнтэй адилтгах бэхжүүлэгчээр бэхжүүлэн зориулалтын тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэлийн аргаар хийхээр зураг төсөлд тусгах;
- Замын трассын дагуу 2 км тутамд хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн хэмжилтийг UTM системд хийж гүйцэтгэх;
- Зам, гүүрийн зурваст орсон болон доогуур хөндлөн өнгөрч байгаа инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах,

сүлжээний техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардлыг тооцож зураг төсөлд тусгах;

- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх;
- Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох;
- Хөдөлгөөний аюулгүй байдлын аудитын дүгнэлт гаргах, тэмдэг, тэмдэгжилтийн талаар тухайн холбогдох байгууллагаас санал авах;
- Замын хөдөлгөөнийг зохион байгуулах техник хэрэгсэл, тоноглолыг оновчтой төлөвлөх;
- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах;

13. Зөвшөөрөлцөх байгууллага,
албан тушаалтан

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хэрхэн нийцэж байгаа талаар ажлын зураг, замын трассын байршлыг аймгийн Ерөнхий архитектортай зөвшилцөж батлуулсан байх;

Хянасан:

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Х.БАХЫТГҮЛ

Баяннуур сумын Засаг дарга

И.ДӨРБЕТХАН

Боловсруулсан:

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн

Е.ДОСЖАН

Баяннуур сумын газрын даамал

С.АЛМАБЕК

Аймгийн Барилга захиалагчийн албаны
Авто замын хяналтын инженер

М.МАРАТБЕК